

БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД
Д.ЦОГТБААТАР

МАОЭНХ-ны ИТГЭМЖЛЭГДСЭН
төлөөлөгч
МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛЫН
БАРИЛГАЧДЫН
ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ
М.БАТБААТАР

МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН
ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛҮҮДИЙН ХОЛБООНЫ
ТАРГА
ХОЛБОО
УЗН03202 1006216
УЛААНБААТАР ХОТ
Б.БАТЦОГТ

БАРИЛГЫН САЛБАРЫН 2015-2016 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хамтын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжинд нийцэж байгаа тул

2015 оны 03 дугаар сарын 04 өдөр бүртгэв.

УЛААНБААТАР ХОТ

2015 оны 2 дугаар сарын 26

Хөдөлмөрийн Яам
Хамтын Хэлэлцээрийг
Бүртгэв

БАРИЛГЫН САЛБАРЫН 2015-2016 ОНЫ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Нийтлэг үндэслэл

Энэхүү хэлэлцээрийг Барилга, Хот Байгуулалтын сайдын 2015 оны 13 дугаар тушаал, Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны шийдвэрээр тус тус эрх олгогдсон төлөөлөгчид /хамтад нь "талууд" гэх/ Хөдөлмөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.5, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх заалт, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2015-2016 оны улсын хэлэлцээрийг үндэслэн 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдөр байгуулав.

Нэг. Барилгын салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар

- 1.1. Төр, хувийн хэвшлийнхэн хамтран "Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн"-ийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, барилгын салбарын тулгамдсан асуудлуудыг хэлэлцүүлж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж, талууд хамтран ажиллана.
- 1.1. Монгол Улсад барилгын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээг 2016 онд тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.
- 1.2. Монгол Улсын Засгийн газрын "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилгот хөтөлбөр", "100 мянган айлын орон сууц", "Нийслэлийн гэр хороололын дахин төлөвлөлт", "Аймгуудын 1000 айлын орон сууц", "Ажилтай орлоготой монгол хүн" зэрэг хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь дэмжинэ.
- 1.3. Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжүүлэхээр холбогдох шийдвэрүүд нь гарсан "Барилга паспортжуулах", "Угсармал орон сууцны дулаан техникийн шинэчлэл", "Улаанбаатар хотын иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны стратеги" зэрэг хөтөлбөр төслүүдийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх тухай шийдвэрийг Засгийн газраар гаргуулна.
- 1.4. "Барилга угсралтын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах асуудлыг зохицуулах нийтлэг журам"-ыг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.5. Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Зөвшөөрлийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөр эрхлэлтийн тухай, Мэргэжлийн боловсролын тухай зэрэг хуулиудын төсөлтэй нийцүүлэх, холбогдох хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах, уг хуулийг батлуулах ажлыг зохион байгуулна.
- 1.6. Засгийн газрын 2010 оны 325 дугаар, 2014 оны 250 дугаар тогтоолд барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэжлийн зэрэг олгох, хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг барилгын салбарын төрийн бус

Хөдөлмөрийн Яам
Хамтын хэлэлцээрийг
Бүртгэв

байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр заасныг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

- 1.7. Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулна.
- 1.8. Нормчлолын сангийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэх, 2015-2016 онд сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэн боловсруулах норм, нормативын баримт бичгийн жагсаалт гаргаж батлуулан, хэрэгжүүлэх. Нормчлолын сангийн зарцуулалтыг ил тод болгож, өмнөх 2 жилийн тайланг гаргуулж, дотоод аудитын гаргуулна.
- 1.9. Улсын Их Хурлын 2014 оны 30 дугаар тогтоолын дагуу Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 18 болон 181 дүгээр тушаалаар батлагдсан "Барилгын төсөв зохиох үндсэн дүрэм", "Барилгын төсөв зохиох аргачлал"-д Мэргэжлийн зөвлөлөөр судлуулж, дүгнэлт гаргуулан, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн талаар

- 2.1. Барилгын салбарын эрэлтэд нийцсэн, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв байгууллагатай "Хамтран ажиллах гэрээ" байгуулах, төр, хувийн хэвшлийн оролцоог хангасан "Барилгын салбарын зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, үйл ажиллагааг идэвхижүүлнэ.
- 2.2. Барилгын салбарт үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш нарыг бэлтгэж, суралцагчид, төгсөгчид, шинээр ажилд орогсдыг ажлын байранд сургаж дадлагажуулах, төгсөгчдийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулна.
- 2.3. Орчин үеийн дэвшилтэт техник технологи бүхий үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдийн санаачилсан жижиг дунд үйлдвэрийн төслүүдийг дэмжиж ажиллана.
- 2.4. "Аутсорсинг хөдөлмөр эрхлэлтийн шинэ гарц" аутсорсингийн үйлчилгээг барилгын салбарт нэвтрүүлнэ.

Гурав. Цалин хөлсний чиглэлээр

- 3.1. Барилгын салбарт тарифын хэлэлцээр байгуулахад шаардлагатай судалгаа, шинжилгээний ажлуудыг холбогдох газруудтай хамтарч зохион байгуулна.
- 3.2. Барилгын салбарт ажиллагсдын хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн байдалд талууд хамтарсан үзлэг хийж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авна.
- 3.3. Барилгын салбарт ажиллагсдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 358848 /гурван зуун тавин найман мянга найман зуун дөчин найм/ төгрөгөөс багагүй байлгах арга хэмжээг авч ажиллана. /Барилгын салбарт ажиллаж байгаа тогооч, үйлчлэгч, харуул зэрэгт хамаарна /

Дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр

- 4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны 2014 оны 11 дүгээр сарын хурлын шийдвэрийн дагуу "Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй

Хөдөлмөрийн Яам
Хамтын хэлэлцээрийг
Бүртгэв

байдал, эрүүл ахуйн дэд” хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэх, дэд хөтөлбөр боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ.

- 4.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарах шийдвэрийг хэрэгжүүлнэ.
- 4.3. “Цэнхэр карт” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулан, хэрэгжүүлнэ.
- 4.4. Барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн захирлууд болон ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд хамруулна.
- 4.5. Олон Улсын “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай” Олон улсын 167 дугаар конвенцид нэгдэн орох асуудлыг судалж, зохион байгуулалтын арга хэмжээ авна.

Тав. Нийгмийн түншлэлийн талаар

- 5.1. Барилгын салбарын шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлуудаар талууд харилцан зөвлөлдөх, мэдээлэл солилцох, хамтын шийдвэрийг хэрэгжүүлнэ. ажиллана.
- 5.2. Барилгын салбарын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх замаар хамтын ажиллагааг дэмжинэ.

Зургаа. Хэлэлцээрийг мөрдөж, хэрэгжүүлэх чиглэлээр

- 6.1. Энэхүү хэлэлцээр нь талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 6.2. Хэлэлцээрийн биелэлтэд талууд хамтран хяналт тавина.
- 6.3. Хэлэлцээрийн үр дүнг хагас, бүтэн жилээр нэгтгэн дүгнэж, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороонд хүргүүлнэ.
- 6.4. Энэхүү хэлэлцээрийн талуудын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөхөд хэлэлцээр дуусгавар болох, хүчингүйд тооцох үндэслэл болохгүй, эрх хүлээн авагчид хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүрэг шилжинэ.
- 6.5. Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 6.6. Энэхүү хэлэлцээрт тусгасан асуудлыг талууд ажлууд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөг талууд өөрсдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангана.
- 6.7. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд үүссэн маргааныг хамтран хэлэлцэх, тохиролцох бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ДЭДСАЙД

Г.БАЙГАЛМАА

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА

У.ОТГОНБАЯР



БАРИЛГА, НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.БААСАН

БАРИЛГЫН ЧАНАР, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ГАНБАТ


ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА

М.БАТБАЯР

**МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН
ХОЛБООГ ТӨЛӨӨЛЖ:**

МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН
ХОЛБООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮД:

 Ц.ЭНХЦЭЦЭГ

 Н.ХИШИГЖАРГАЛ

 Р.ЭЛБЭГБАЯН

 Д.ТӨГСБАЯР

 Б.ЦЭРЭНДУЛАМ

ХОТ БАЙГУУЛАЛТ, НИЙТИЙН АЖ
АХУЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОЛБООНЫ ДАРГА

 Ч.ЧИМЭГ

АЖИЛ ОЛГОГЧДЫГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ
ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



М.ТҮМЭНЖАРГАЛ

ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
КОРПОРАЦИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ,
МАОЭНХ-НЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН


 Б.ЖҮГДЭР

МОНГОЛЫН БАРИЛГЫН
ИНЖЕНЕРҮҮДИЙН ХОЛБООНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




Б.ГАНТӨМӨР

БАРИЛГЫН АХМАДЫН ХОРООНЫ
ДАРГА



Л.ТОГТОХБАЯР

БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ



П.НАРАНДАЛАЙ

Хөдөлмөрийн Яам
Хамгийн холбооноос
Бүртгэл